



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

Түр заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Улсын онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг гэрээр эмчлэх, хянах түр зааврыг хавсралтаар баталсугай.


2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг гэрээр эмчлэх, хянахад чиглэсэн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг гэрээр эмчлэх, хянах чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа), Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл (Д.Мягмарцэрэн), мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буянтогтох)-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/247 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141210478

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 05 сарын 04 -ны өдрийн тушаалын
нэгдүгээр хавсралт 101

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон
эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг
гэрээр эмчлэх, хянах түр заавар

Үндэслэл

ДЭМБ-аас гаргасан “Коронавируст халдвар (КОВИД -19)-ын эмнэлзүйн менежмент” (27.05.2020), БНХАУ-ын “Шинэ коронавируст хатгааны оношилгоо, эмчилгээний протокол” (Хувилбар 7), Европын холбооны Өвчний тандалт судалгааны төвийн (Эмнэлгээс гаргах болон тусгаарлалтыг зогсоох удирдамж) ECDC, 2020, АНУ-ын Өвчний тандалт судалгааны төвийн 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Тусгаарлалтын хугацааны заавар”, ДЭМБ-ын Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнийг тусгаарлалтаас гаргах шинэчилсэн заавар 6 дугаар сарын 17-ны шинэчилсэн товч зөвлөмж, Япон улсын “Эмнэлзүйн удирдамж” 2020 НИН Коронавируст халдвар (КОВИД-19)-ын “Эмчилгээний удирдамж” ОХУ-ын ЭМЯ-ны “Шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ”-ний түр удирдамж (26.10.2020), Коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөний эмнэлзүйн менежмент: Эрүүл мэндийн ажилтанд зориулсан заавар (2.1 хувилбар, 17.03.2020), “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй эсвэл батлагдсан тохиолдлын гэрийн эмчилгээ, тусгаарлалт, ойрын хавьтлын менежмент” (12.08.2020) зэрэг зааврууд шинэчлэгдэн гаргасан.

Зорилго

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, шинж тэмдэг илрээгүй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрээр өвчилсөн, коронавируст халдварын хүнд хэлбэрээр өвдөх эрсдэлт хүчин зүйлсгүй тохиолдлыг гэрээр эмчлэх, хянах, эмнэлгийн тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэхэд эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил арга зүйгээр хангах.

Нэг. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдлын тодорхойлолт:

1.1. Сэжигтэй тохиолдол

А. Эмнэлзүйн шалгуур:

1. Халуурах, ханиалгах зэрэг амьсгалын замын цочмог халдварын шинж тэмдэг илэрсэн ЭСХҮЛ
2. Халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, амьсгалын дээд замын үрэвсэх, үнэр, амт мэдрэхгүй байх, амьсгаадах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, сэтгэл санаа тогтворгүй болох зэрэг эмнэлзүйн шинж тэмдгээс 3 болон түүнээс дээш илэрсэн

Тархвар судлалын шалгуур:

1. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 14 хоногийн өмнө Коронавируст халдвар (КОВИД-19) тархах өндөр эрсдэлтэй тусгаарлан ажиглах байр, олон хүнийг нэг дор байршуулсан нийтийн байр зэрэгт ажиллаж эсхүл амьдарч байсан ЭСХҮЛ
2. Эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 14 хоногийн өмнө Коронавируст халдвар (КОВИД-19) хүн амын дунд өргөн тархсан газарт амьдарч байсан буюу аялсан ЭСХҮЛ
3. Эмнэлзүйн шинж тэмдэг эхлэхээс өмнөх 14 хоногт эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байсан эсхүл үйлчлүүлж байсан;

Б. Тархвар судлалын холбогдолгүй боловч амьсгалын замын цочмог хүнд халдвартай, сүүлийн 10 хоногт өвчин эхэлж, 38⁰С хэм болон түүнээс дээш халуурч, ханиалгасан, зайлшгүй эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай;

В. Тархвар судлалын холбогдолгүй, эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй боловч SARS-CoV-2 антиген илрүүлэх хурдавчилсан оношлуураар эерэг тодорхойлогдсон тохиолдлыг хэлнэ.

1.2. Магадлалтай тохиолдол

А. Дээрх эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрсэн бөгөөд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолтой хавьтал болсон, тархвар судлалын хувьд батлагдсан тохиолдлын голомтод хамаарах SARS-CoV-2 антиген илрүүлэх хурдавчилсан оношлуураар эерэг тодорхойлогдсон;

Б. Дүрс оношилгоогоор уушгинд дараах шинжээс аль нэг илэрсэн. Үүнд:

- Цээжний рентген зурагт уушгины доод дэлбэнгийн захаар байрласан дугираг нэвчдэс сүүдэр илэрсэн;
- Цээжний компьютерт томографийн шинжилгээнд уушгины доод дэлбэнгийн захаар байрласан дугариг нэвчдэст сүүдэр буюу хоёр талыг хамарсан олон тооны бүдэг нэвчдэс “Бүүдгэр шилний шинж” илэрсэн;
- Уушгины хэт авиан шинжилгээнд зузаарсан гялтан хальсны шугам, Б шугам (олон тооны, нийлмэл болон салангад), гуурсан хоолойн зураглалтай болон зураглалгүй нийлмэл өөрчлөлт илэрсэн;

В. Ямар нэг шалтгаангүйгээр гэнэт үнэр эсвэл амт мэдрэхгүй болсон;

Г. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын магадлалтай болон батлагдсан тохиолдолтой хавьтал болсон, тархвар судлалын хувьд батлагдсан тохиолдлын голомтод хамаарах шалтгаан тодорхойгүй амьсгалын дистресс хам шинжээр нас барсан тохиолдлыг хэлнэ.

1.3. Батлагдсан тохиолдол

Эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн эсэхээс үл хамааран бодит хугацааны Полимеразийн гинжин урвал (бх-ПГУ)-ын шинжилгээгээр Коронавируст халдвар (КОВИД-19)-тай болох нь тогтоогдсон тохиолдлыг хэлнэ.

1.4.Хавьтал

1.4.1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын магадлалтай болон батлагдсан тохиолдолтой эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 2 хоногт, шинж тэмдэг илэрснээс хойших 14 хоногийн хугацаанд хавьтал болсох ЭСХҮЛ;

Эмнэлзүйн шинж тэмдэггүй боловч лабораторийн шинжилгээнд онош батлагдахын өмнөх 2 хоногоос сүүлийн 14 хоногийн хугацаанд хавьтал болсон хүнийг тооцно.

1.5. Шинж тэмдэггүй Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдол: Шинж тэмдэг илрээгүй, SARS-CoV-2 шинжилгээнд хариу нь эерэг гарсан боловч хяналтын явцад шинж тэмдэг илрээгүй.

1.6. Хөнгөн хэлбэрийн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдол: Дархлаа дарангуйлагдаагүй, эмзэг бүлгийн хүн амтай амьдардаггүй КОВИД-19-ийн батлагдсан эсвэл магадлалтай тохиолдол.

1.7. Оношийн код:

ОУӨА-10 ангиллын дагуу коронавируст халдвар (КОВИД-19) оношийн кодыг бичнэ:

U.07.1 - Вируслогийн шинжилгээгээр батлагдсан тохиолдол

U.07.2-Эмнэлзүй болон эпидемиологийн шалгуур үзүүлэлтээр коронавируст халдвар (КОВИД-19) онош тавигдсан боловч лаборатори, вируслогийн шинжилгээ нь баталгаатай бус эсвэл хийгдэх боломжгүй тохиолдол

Z03.8 – Коронавируст халдвар (КОВИД-19) сэжиглэн ажиглалтад буй тохиолдол

Z22.8 –Коронавируст халдвар тээгч

Z11.5 - Коронавируст халдварыг (КОВИД-19) илрүүлэх зорилгоор хийгдэж буй тандалт (скрининг)

Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тохиолдлын эрт илрүүлэлт, эрэмбэлэн ангилалт

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлыг хамгийн эхний хандсан эрүүл мэндийн байгууллага, тасаг /нэгж (Яаралтай тусламжийн тасаг, амбулатори/клиник гэх мэт) нь тархварзүйн асуумж, эмнэлзүйн шинжүүдээр илрүүлж, тусгаарлана. Эрүүл мэндийн байгууллагын түвшинд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлыг батлагдсан зааврын дагуу илрүүлж, тусгаарласны дараа өвчтөний биеийн байдалд үнэлгээ өгнө. Шаардлагатай тохиолдолд холбогдох шинжилгээг хийнэ.

Гурав. Гэрээр эмчлэх, хянах тохиолдолд хийх үнэлгээ

Коронавируст халдвар (КОВИД-19)-т өртсөн тохиолдлыг гэрээр тусгаарлан эмчлэх шийдвэр гаргахад дараахь 3 төрлийн үнэлгээг хийх ба бэлтгэгдсэн эрүүл мэндийн ажилтан тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

3.1. Өвчтөний эмнэлзүйн үнэлгээ

- Өвчтөнд илрэх эмнэлзүйн шинж тэмдэг, дэмжих эмчилгээ шаардлагатай эсэх, өвчин хүндрэх эрсдэлт хүчин зүйлс (60-аас дээш настай,

таргалалттай, зүрх судас, чихрийн шижин, элэг, бөөр, бодисын солилцооны архаг өвчин, хавдартай, сэтгэцийн эмгэгтэй, жирэмсэн эмэгтэй, дархлаа дарангуйлагдах эмгэгтэй, дархлаа дарангуйлагдах эм хэрэглэж байгаа) байгаа эсэх,

- Өвчтөнд шинж тэмдэг илрээгүй эсхүл хөнгөн шинж тэмдэг илэрсэн, коронавируст халдварын хүнд хэлбэрээр өвдөх эрсдэлт хүчин зүйлсгүй,
- Өвчтөнд халдвар хамгааллын дэглэмийг сахих, заавар зөвлөмжийг мөрдөх нөхцөл байгаа эсэх,
- Эмнэлзүйн шинж тэмдгийг бэлтгэгдсэн эрүүл мэндийн ажилтан тогтмол хянах боломжтой эсэхэд үнэлгээ өгнө.

3.2. Гэр ахуйн орчин нөхцлийн үнэлгээ

- Өвчтөн гэртээ ганцаараа амьдардаг эсэх, тийм бол түүнд тусалж, дэмжлэг үзүүлэх хүн, сүлжээ байгаа эсэх,
- Өвчтөнийг гэрт нь тусгаарлан эмчлэх орчин нөхцөл (ам бүлийн тоо, зай талбай, гэр бүлийн гишүүдийн нас, эрүүл мэндийн байдал) бүрдсэн эсэх,
- Гэр бүлийн гишүүд нь COVID-19-ын талаар болон халдвар тархахаас урьдчилан сэргийлэх мэдлэгтэй эсэх, нэмэлт ямар нэгэн мэдээлэл хэрэгтэй эсэх, хаанаас тусламж, үйлчилгээ, мэдээлэл авахаа мэддэг эсэх,
- Өвчтөн хүүхэдтэй эсэх, хүүхдийг асрах хамгаалах хүн байгаа эсэх,
- Гэр бүлийн гишүүдээс нэг хүн өвчтөний асран хамгаалагчаар хамт байх боломжтой эсэх,
- Өвчтөн өөрөө болон асран хамгаалагч, гэр бүлийн гишүүд нь гэрээр тусгаарлан эмчлэхийг зөвшөөрч байгаа эсэх,
- Өвчтөн болон гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн дэмжлэг хэрэгтэй байгаа эсэх,
- Гэр бүлийн гишүүдийн дотор 60-аас дээш насны ахмад настан, архаг суурь өвчтэй, сэтгэцийн эмгэгтэй, дархлаа дарангуйлах эмгэгтэй, 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, байнгын асаргаа шаардсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа эсэх,
- Халдвараас сэргийлэх дэглэм, заавар, зөвлөмжийг мөрдөх, гарын ариун цэврийг сахих, бусад ариун цэврийн хэрэгслийн нөөц, орчны цэвэрлэгээний материалыг хэрэглэх, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хийх боломжтой эсэх,
- Хүний хөл хөдөлгөөнийг хязгаарлах боломжтой эсэх,
- Өвчтөн ба асран хамгаалагчийн аль аль нь хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах эдийн засгийн боломж байгаа эсэхийг үнэлнэ.

3.3. Эмнэлзүйн шинж тэмдгийн өөрчлөлтийг хянах

- Эрүүл мэндийн ажилтан гэрт суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжтой эсэх,
- Өвчтөний шинж тэмдэг багасаж, эдгэрэх хүртэл асран халамжлагч болон эмнэлгийн ажилтан, нийгмийн ажилтнууд тогтмол харилцаа холбоотой байж, өвчтөнг хянах нөхцөл байгаа эсэх,

- Гэрээр эмчлэгдэж байгаа өвчтөний хяналтыг бэлтгэгдсэн эмнэлгийн мэргэжилтэн гэрт нь очиж эсхүл утас, цахимаар хянах боломжтой эсэхийг үнэлнэ.

3.4. Үнэлгээгээр гэрийн эрүүл ахуйн орчин нөхцөл хангалтгүй, 5-аас дээш ам бүлтэй, нийтийн байранд амьдардаг, гэр бүлийн гишүүдийн дотор 60-аас дээш настай ахмад, архаг суурь өвчтэй, сэтгэцийн эмгэгтэй, дархлаа дарангуйлах эмгэгтэй, 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, байнгын асаргаа шаардсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа тохиолдолд гэрээр эмчлэхгүй.

Дөрөв. Эмнэлзүйн шинж тэмдэг

Тархвар зүйн судалгаагаар эмнэлзүйн нууц хугацаа 14 хоног хүртэл үргэлжилнэ.

Халдварт өртснөөс хойш өвчний шинж тэмдэг илрэх хүртэлх хугацаа дунджаар 4-5 хоног байна. Өвчтөний 80 хувьд өвчний явц хөнгөн, 20 орчим хувь нь уушгины хатгаагаар өвдөж байна.

Ихэвчлэн халуурах, ханиалгах, хоолой өвдөх, хамар битүүрэх, нус гоожих, толгой өвдөх, ядрах, мөн үнэрлэх, амтлах мэдрэхүй алдагдах зэрэг эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрнэ. Цөөн тохиолдолд суулгах, бөөлжих шинж тэмдэг илэрдэг.

Коронавируст халдвар (КОВИД-19) –ын эмнэлзүйн дээрх шинж тэмдгүүд илэрсэн боловч амьсгаадах, амьсгал давчдах шинж тэмдэг эсхүл цээжний дүрс оношилгооны шинжилгээнд өөрчлөлт илрээгүй тохиолдолд халдварын хөнгөн хэлбэр гэж үзнэ.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй, SARS-CoV-2 батлагдсан тохиолдлын эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй, эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн хяналтан дор гэрээр эмчилж, хянана.

Тав. Ялган оношилгоо

- Томуу, бусад вируст (риновирус, аденовирус, респиратор синтициаль вирус, хүний метапневмовирус, MERS-CoV зэрэг) цочмог халдвар
- Вируст гастроэнтерит
- Амьсгалын замын бактерийн шалтгаант халдвар зэргээс ялган оношилно.

Ялган оношилгоонд тархварзүйн өгүүлэмж, эмнэлзүйн шинж тэмдэг, тэдгээрийн явц хөдлөлзүй зэргийг харгалзан үзнэ.

Сэжигтэй тохиолдол бүрт SARS-CoV-2 үүсгэгч, бусад үүсгэгчийг тодорхойлох лабораторийн шинжилгээ хийнэ.

Хүүхдэд эмнэлзүйн шинж тэмдэг харьцангуй хөнгөн явагддаг. Зарим тохиолдолд бөөлжих, суулгах, мөн бага зэрэг амьсгаадах, амьсгал давчдах шинж тэмдэг илэрнэ.

Зургаа. Эмчилгээ

- Ихэнх хөнгөн тохиолдолд өвөрмөц эмчилгээ хийх заалтгүй, шаардлагатай тохиолдолд шинж тэмдгийн эмчилгээ хийнэ. Үүнд: халуун бууруулах, өвдөлт намдаах эм хэрэглэх гэх мэт,
- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал эмчилгээ,
- Эмчилгээ болон урьдчилан сэргийлэх зорилгоор вирусийн эсрэг бэлдмэл, антибиотик эмчилгээ хэрэглэхгүй,
- Хүчилтөрөгч эмчилгээ шаардлагагүй, бактерийн шалтгаант ринит, синусит, бронхиттай өвчтөнд амоксициллин, доксициклин, макролидын бүлгийн антибиотик уухаар хэрэглэж болно,
- Өвчтөний биеийн байдал, эмнэлзүйн шинж тэмдгийг тогтмол хянаж, дараахь шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хэвтүүлнэ. Үүнд: 38°C -аас дээш халуурах, амьсгалын тоо 20-иос дээш болох, зүрхний цохилтын тоо 100-аас дээш болох, $\text{SpO}_2 < 94\%$ болох, цээж давчдах, амьсгаадах зэрэг шинж тэмдгийг анхаарах,
- Үзлэг, шинжилгээгээр өвчтөнг хөнгөн гэж оношлогдсон ч өвчин хурдан даамжирч болзошгүй тул сайтар хянах. Өвчин даамжирч буйг хүчилтөрөгч дутагдлын (хөхрөлт, амьсгаадалт гэх мэт) шинж тэмдгүүд илтгэнэ.
- Уламжлалт анагаах ухааны эмчийн зөвлөгөө, хяналтын дор идээ унд, явдал мөр, эмийн болон засал эмчилгээг хийнэ.

Долоо. Эмчилгээний үргэлжлэх хугацаа

- **Шинж тэмдэггүй Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдол:** SARS-CoV-2 шинжилгээнд хариу нь зэрэг гарсан өдрөөс хойш гэрээр 14 хоног тусгаарлан хянана.
- **Хөнгөн хэлбэрийн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдол:** КОВИД-19 эмнэлзүйн шинж тэмдэг илэрснээс хойш 14 хоног өнгөрсөн бөгөөд хамгийн багадаа 3 хоногийн турш халуураагүй.

Найм. Гэрийн дэглэм, хяналт

- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хөнгөн хэлбэрийг гэрт нь тусгаарлан эмчлэхэд халдвар хамгааллын дэглэмийг сахих нөхцөлийг бүрдүүлнэ.
- Халуун бүлээн шингэн зүйл сайн уух, илчлэг сайтай хоол хүнс хэрэглэхийг зөвлөнө,
- Өрх, сум, тосгоны эмч шаардлагатай гэж үзвэл лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч нараас зөвлөгөө авах, хамтран үзлэг, шинжилгээ хийх, эмчилгээг өөрчлөх болон эмнэлэгт шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- Өрх, сум, тосгоны эмч өдөрт 2 удаа асуумж авах ба хэрэв шинж тэмдэг нэмж илэрвэл ХӨСҮТ-ийн 100 дугаарын утсанд, орон нутагт аймгийн шуурхай хариу арга хэмжээний багт мэдээлнэ.
- ХӨСҮТ-ийн болон аймгийн шуурхай ажиллагааны баг нь өвчтөнг эмнэлэгт тээвэрлэн хэвтүүлэх тусламж, үйлчилгээг зохицуулна.
- Гэрээр эмчлэгдэж байгаа өвчтөнийг эдгэртэл сум, өрх, тосгоны эмч байнга

холбоотой байж, биеийн байдал, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгүүдийг утсаар тогтмол лавлан, шаардлагатай зөвлөгөө мэдээлэл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хөнгөн хэлбэрээр өвчилсөн тохиолдлыг гэрээр эмчлэх, хянахад эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/248 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан нийтлэг зааврыг мөрдөж ажиллана.

Ес. Халдвараас сэргийлэх дэглэм

9.1. Өвчтөний гэр бүлийнхэн, асран хамгаалагч нь гэрийн нөхцөлд халдвар дамжихаас сэргийлж дараахь дэглэмийг баримтална. Үүнд:

- Өвчтөнг агааржуулалт сайтай өрөөнд байлгана.
- Өвчтөнг нэг эрүүл хүн асарч, сувилна.
- Гэр бүлийн бусад гишүүдээс тусад нь өөр өрөөнд байлгах, боломжгүй бол өвчтөний орыг гэр бүлийн бусад гишүүдээс нэг метрээс доошгүй зайд байрлуулж, тусгаарлах хаалт хийнэ.
- Өвчтөнийг гэрээс гаргахгүй бөгөөд өрөөний цонхыг тогтмол нээж, агааржуулна.
- Өвчтөн бие зассаны дараа суултуурын тагийг таглаж усаа татах, ариун цэврийн өрөөг хэрэглэсэн тохиолдол бүрт ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодисоор цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.
- Асран хамгаалагч нь өвчтөний өрөөнд орох бүртээ амны хаалт зүүнэ.
- Өвчтөнг асарч дуусаад гараа угааж амны хаалтыг тайлах ба үүний дараа гараа давтан савантай бүлээн усаар сайтар угаана.
- Хоол идэхийн өмнө болон дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, өвчтөний бие түүний эргэн тойронд хүрэлцсэн бол гараа савантай бүлээн усаар заавал угаана.
 - Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодис хэрэглэнэ. Уг халдваргүйжүүлэх бодисыг залгих, уухаас сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангана.
 - Өрөөний “байнга хүрдэг” хэсгүүд (ширээний тавцан, тавиур, гар утас, компьютерийн гар, таблет, орны хажуугийн шүүгээний тавцан, ариун цэврийн өрөөний эд зүйлс)-ийн гадаргууг өдөр бүр цэвэрлэнэ;
- Гараа савандаж угаасны дараа нэг удаагийн алчуур, салфетка хэрэглэх, боломжгүй бол даавуун алчуурт арчин ба хэрэглэсэн алчуурыг сайтар савандаж угаана.
- Өвчтөн ханиах, найтаах үед нэг удаагийн алчуур, салфетка хэрэглүүлж, хэрэглэсэн алчуур, салфеткийг шууд хаяна, эсвэл гарыг нугалж, тохойн дотор тал руу ханиаж, найтаалгана.
- Өвчтөний нус, цэр, шүлс, шээс, өтгөн, цусанд хүрэлцэхээс зайлсхийх, тэдгээрт хүрэлцэх, цэвэрлэх үедээ ус нэвтэрдэггүй материалаар хийсэн хормогч, нэг удаагийн бээлий өмсөх ба тэдгээрийг тайлах бүртээ гарын ариун цэврийг сайтар сахина.

- Өвчтөн болон өвчтөнийг асрахад хэрэглэсэн бээлий, салфетка, амны хаалт, бусад хог хаягдлыг тусад нь савлаж хаяна.
- Өвчтөний ахуйн хэрэгслийг гэр бүлийн гишүүдийнхээс тусад нь байршуулах, (шүдний сойз, хоолны хэрэгсэл, алчуур, орны цагаан хэрэглэл) гал тогоо, хоолны хэрэгслийг зориулалтын бодистой халуун усаар сайтар угаана. Хэрэглэсэн усыг дахин ашиглахгүй.
- Усаар шингэрүүлсэн цайруулагчийн (белизна) уусмалаар өвчтөний ор түүний орчимд байрлах ширээ болон бусад эд хогшлыг өдөр бүр цэвэрлэж, хаалганы бариулд хүрсэн тохиолдол бүрийн дараа угаана. Усаар шингэрүүлсэн уусмалыг бэлтгэхдээ 99 мл усанд 1 мл цайруулагч бодис (белизна) байхаар тооцно.
- Өвчтөний өмссөн хувцас, хэрэглэсэн орны цагаан хэрэглэл, гар, нүүрний болон биеийн алчуур зэргийг тусгай уут, саванд хийж цельсийн 60-90°C хэмийн халуун усанд гараар эсвэл угаалгын машинд угаах ба харин сэгсрэх болон арьсанд хүргэхээс зайлсхийнэ.

Арав. Тусламж, үйлчилгээний зохицуулалт

- 10.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг гэрээр эмчлэх, хянах багийг томилж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.
- 10.2. Гэрээр эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхээр сургаж, бэлтгэгдсэн эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь харьяа хорооны нийгмийн ажилтантай хамтран ажиллана.
- 10.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь эмчилгээ, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангана.
- 10.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг эмчлэхэд өвчний түүх хөтөлнө.
- 10.5. Эмчилгээ, үйлчилгээний санхүүжилт нь эрүүл мэндийн даатгалын сангийн холбогдох тогтоол, журмаар зохицуулагдана.